



**МОНГОЛ УЛС**  
**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ**  
**ТОГТООЛ**

2012 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

**“Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөө, давхар даатгалын үйл ажиллагаанд тавигдах шаардлага, түүний биелэлтэд хяналт тавих журам”-ыг шинэчлэн батлах тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.3, 14.2.16 дахь заалтыг тундуслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөө, давхар даатгалын үйл ажиллагаанд тавигдах шаардлага, түүний биелэлтэд хяналт тавих журам” -ыг хавсралт 1-ээр шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны “Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага, түүний биелэлтэд хяналт тавих тухай журам”-ыг батлах тухай 65 дугаар тогтоолүнийгүй болсонд тооцсугай.

3. Энэ журмыг 2012 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Д.Нямцэрэн/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

**ДААТГАГЧИЙН ДАВХАР ДААТГАЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ДАВХАР ДААТГАЛЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ТҮҮНИЙ БИЕЛЭЛТЭД  
ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ЖУРАМ**

**Нэг.Нийтлэг зүйл**

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй компани (цаашид “даатгагч” гэх) нь даатгалын гэрээгээр үлээн авсан эрсдэлээ хэсэгчлэн болон бүхэлд нь давхар даатгуулах, фронтингийн даатгалын үйл ажиллагаа явуулах, давхар даатгалын төлөвлөгөө гаргах, түүний биелэлтэд Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос хяналт тавихтай холбоотойгоор үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Даатгагч нь даатгалын үйл ажиллагааны эрсдэлээ Хорооноос, эсхүл гадаад улсын эрх бүхий байгууллагаас давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компани (цаашид “давхар даатгагч” гэх)-д болон давхар даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компани (цаашид “давхар даатгалын зуучлагч” гэх)-д давхар даатгуулах буюу давхар даатгалаа зуучлуулна.

**Хоёр. Давхар даатгалын нэр томъёо**

Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог дараах утгаар ойлгоно:

2.1 “Давхар даатгалын гэрээ” гэж даатгагч даатгуулагчийн өмнө хүлээсэн эрсдэлээ хэсэгчлэн болон бүхэлд нь нэг, эсхүл хэд хэдэн давхар даатгагчид шилжүүлсэн тухай гэрээг;

2.2 Давхар даатгалын гэрээ дараах төрөлтэй байна:

2.2.1 “Факультатив давхар даатгал” (Facultative) гэж даатгагч нь даатгуулагчийн өмнө хүлээсэн эрсдэлийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь даатгалын гэрээ тус бүрээр давхар даатгагчтай тохиролцож давхар даатгуулах үйл ажиллагааг;

2.2.2 “Гэрээт давхар даатгал” (Treaty) гэж даатгагч давхар даатгуулахаар санал болгосон даатгалын эрсдэлийг давхар даатгагч тохиролцсон хязгаарын хүрээнд шууд давхар даатгах үйл ажиллагааг;

2.2.3 “Фронтингийн давхар даатгал” (fronting) гэж (цаашид “фронтингийн үйл ажиллагаа” гэх) дараах нөхцөлд хамаарах давхар даатгалын үйл ажиллагааг:

1/Гадаадын даатгагч, давхар даатгагч, давхар даатгалын зуучлагч нөрсдөө даатгалын андеррайтинг (гэрээний нөхцөл, шаардлагын дагуу даатгалын эрсдэлийн үнэлгээ, хураамжийн хэмжээ, нөхөн төлбөрийн тооцоолол) хийсний үндсэн дээр Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй даатгагчаар дамжуулан даатгалын эрсдэлийг хэсэгчлэн болон бүхэлд нь давхар даатгах үйл ажиллагааг; эсхүл

2/Хорооноос тухайн давхар даатгалын үйл ажиллагааг даатгалын фронтингийн үйл ажиллагаа гэж үзсэн.

2.2.4 Давхар даатгалын үйл ажиллагааны бусад хэлбэр.

2.3 “Давхар даатгалын баталгаа” (reinsurance slip) гэж давхар даатгагч даатгалын эрсдэлийг даатгах болсныг баталгаажуулсан баримт бөгөөд үүнд давхар даатгалын гэрээний нөхцлийн хураангуй болон шаардлагатай бусад мэдээллийг тусгасан байна;

2.4 “Давхар даатгалын мэдэгдэл” (cover note) гэж давхар даатгалын зуучлагчаас даатгагчид ирүүлсэн давхар даатгалын гэрээ байгуулагдсаныг нотлох баримт бөгөөд үүнд давхар даатгалын гэрээний нөхцлийн хураангуйг тусгасан байна;

2.5 “Даатгагчийг гэрээт үүргээс чөлөөлөх” (Cut through clause) гэж давхар даатгагч даатгалын нөхөн төлбөрийг даатгуулагчид шууд олгосноор даатгагчийг гэрээт үүргээс нь чөлөөлж, түүний үүргийг өөртөө шилжүүлж авсан давхар даатгалын гэрээний нөхцлийг.

Энэхүү нөхцөл нь:

2.5.1 Даатгуулагчийн хүсэлт гаргасан;

2.5.2 Даатгагч Хорооноос фронтингийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан болон даатгагч даатгалын нөхөн төлбөрийг төлж чадахгүй болсон тохиолдолд хэрэгжинэ.

2.6 “Зөвшөөрөгдөх давхар даатгагч” гэж:

2.6.1 Хорооноос давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан давхар даатгагчийг;

2.6.2 Хорооноос давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл аваагүй буюу дараах гадаадын давхар даатгагчийг:

1/ “A.M. Best Company”-ийн “A”-аас дээш;

2/ “Standard and Poors”, “Fitch Group”-ийн “BBB”-ээс дээш;

3/ “Moody’s Corporation”-ийн “Baa”-аас дээш үнэлгээ авсан.

2.7 “Гадаадын давхар даатгагч” гэж Хорооноос давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай эвшөөрөл аваагүй буюу гадаад улсад байгуулагдаж, Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна давхар даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийг, эсхүл түүнийг төлөөлсөн этгээдийг;

2.8 “Гадаадын даатгагч, даатгалын зуучлагч” гэж Хорооноос даатгалын болон даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай эвшөөрөл аваагүй буюу гадаад улсад байгуулагдаж, Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна даатгалын болон даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд, эсхүл түүнийг төлөөлсөн этгээдийг.

### **Гурав. Давхар даатгалын төлөвлөгөө, түүнд тавих шаардлага**

3.1 Даатгагч нь Даатгалын тухай хуулийн 47 дугаар үйлд заасны дагуу даатгалын эрсдэлийг хариуцах үүргээ давхар даатгуулах төлөвлөгөө (цаашид “Давхар даатгалын төлөвлөгөө” гэх)-тэй байна. Давхар даатгалын төлөвлөгөөг тухайн даатгалын компанийн бизнес төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) эсвэл түүнтэй адил эрх бүхий этгээд батална.

3.2 Давхар даатгалын төлөвлөгөө нь давхар даатгалын стратеги төлөвлөгөө, жилийн төлөвлөгөөнөөс бүрдэнэ.

3.3 Давхар даатгалын стратегийн төлөвлөгөө нь тухайн даатгагчийн давхар даатгалын бодлогыг тодорхойлох үндсэн баримт бичиг байх бөгөөд үүнд дараах зүйлсийг тусгана:

3.3.1 Даатгагчийн хүлээж болох нийт эрсдэлийн дээд хязгаар болон даатгалын нэг гэрээгээр хүлээх эрсдэлийн дээд хэмжээг тодорхойлох аргачлал;

3.3.2 Давхар даатгагчийг сонгох, түүний үйл ажиллагааны найдвартай, хэвийн байдлын талаар үнэлэлт, дүгнэлт гаргах үйл ажиллагааны журам;

3.3.3 Давхар даатгалын үйл ажиллагаанд тавих хяналт, тайлагнал, дотоод хяналтын дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох, давхар даатгалын үйл ажиллагааг хариуцаж ажиллах боловсон хүчний нөөцийн талаар баримтлах бодлого;

3.3.4 Давхар даатгалын өмнө төлбөр болон хохирлын нөхөн төлбөрийг төлөх үйл ажиллагаа нь цаг хугацааны хувьд хоорондоо тохирохгүй байх нөхцөлд бэлэн мөнгөний урсгалыг зохицуулах арга зам;

3.3.5 Факультатив болон гэрээт давхар даатгалд хамрагдах шалгуур үзүүлэлтийн талаар;

- 3.3.6 Хамтарч ажиллах давхар даатгагч, давхар даатгалын зуучлагчийн жагсаалт;
- 3.4 Давхар даатгалын тухайн жилийн төлөвлөгөөнд дараах зүйлсийг тусгана:
- 3.4.1 Даатгагчийн хүлээж чадах нийт эрсдэлийн дээд хязгаар болон даатгалын нэг гэрээгээр хүлээх эрсдэлийн дээд хэмжээг давхар даатгалын стратеги төлөвлөгөөнд заасан аргачлалын дагуу тодорхойлсон байх;
- 3.4.2 Давхар даатгуулах даатгалын хэлбэрүүд;
- 3.4.3 Тухайн онд хамтарч ажиллах давхар даатгагч, давхар даатгалын зуучлагч нарын жагсаалт;
- 3.4.4 Давхар даатгалын үйл ажиллагааг эрхлэх, түүний хяналт, тайлагналын талаар авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа (шинээр бий болгох бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц, тайлагнал, үүнтэй холбоотой хэлэлцүүлэг хийх журам зэрэг);
- 3.4.5 Өөрт үлдээх даатгалын эрсдлийн хязгаар (даатгалын хэлбэр тус бүрээр);
- 3.4.6 Факультатив болон гэрээг давхар даатгалд хамруулах даатгалын хэлбэр, давхар даатгалын хэмжээ зэрэг болно.
- 3.5 Даатгалын тодорхой нэг зүйлийн эрсдэлийг давхар даатгуулах гэрээний нөхцөл нь анхны даатгалын гэрээний нөхцөлөөс буурахгүй буюу илүү таатай нөхцөлтэй байна.
- 3.6 Даатгагч нь өөртөө үлдээх гэрээний эрсдэлийн хэмжээнд тохирсон хөрөнгийн чадвартай байвал зохино.
- 3.7 Даатгагч нь давхар даатгагчид шилжүүлэх даатгалын эрсдлийн хэмжээг тогтоохдоо давхар даатгагч тус бүрийн гэрээний үүргээ биелүүлэх санхүүгийн чадавхийг үнэлж дүгнэх шаардлагатай бөгөөд даатгалын эрсдэлээ тараан байршуулах зарчмыг баримтлана.
- 3.8 Даатгагч нь энэхүү журмын 3.1 -д заасан компанийн ТУЗ, эсжүл түүнтэй адил эрх бүхий этгээдийн баталсан давхар даатгалын төлөвлөгөөг Хороонд ирүүлж хянуулах бөгөөд энэхүү журмын 3.4-т заасан давхар даатгалын жилийн төлөвлөгөөг өмнөх оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Хороонд шинээр ирүүлнэ.
- 3.9 Хороо даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөө энэхүү журмын 3 дугаар хэсэгт заасан шаардлагыг бүрэн хангасан, түүнд тусгагдсан мэдээлэл нь үнэн зөв, бодитой байна гэж үзвэл давхар даатгалын жилийн төлөвлөгөөг зөвшөөрч, энэ тухай мэдэгдлийг уг төлөвлөгөө хянагдаж зөвшөөрөгдсөн өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор даатгагчид

бичгээр хүргүүлнэ. Хэрэв давхар даатгалын төлөвлөгөөг шаардлага хангаагүй гэж үзвэл Хороо уг төлөвлөгөөг буцаах үндэслэлийн хамтаар даатгагчид албан бичгээр хүргүүлнэ.

3.10 Давхар даатгалын төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд энэ тухай үжэлтээ 10 хоногийн дотор Хороонд бичгээр мэдэгдэж, шинэчлэгдсэн төлөвлөгөөг ирүүлж зөвшөөрүүлнэ.

#### **Дөрөв. Давхар даатгалын гэрээ байгуулах үйл ажиллагаа**

4.1 Хэрэв даатгалын нэг удаагийн тохиолдол болоход даатгалын гэрээний дагуу даатгуулагчийн өмнө хүлээсэн эрсдэлийн хариуцлагын хэмжээ нь даатгагчийн нийт хөрөнгийн хэмжээнээс давахаар байвал даатгагч тухайн даатгалын эрсдэлийн хариуцлагыг давхар даатгагчид заавал даатгуулна.

4.2 Даатгагч нь дараах тохиолдолд давхар даатгалын гэрээ байгуулах эвшөөрлийг Хорооноос авна:

4.2.1 Давхар даатгагч нь энэхүү журмын 2.6-д заасан эвшөөрөгдөх давхар даатгагчийн шалгуурыг хангаагүй;

4.2.2 Давхар даатгалын гэрээнд гадаадын даатгагч хамтран оролцсон;

4.2.3 Даатгагч фронтингийн үйл ажиллагаа явуулах шаардлагатай болсон.

4.3 Даатгагч энэ журмын 4.2-т заасан давхар даатгалын гэрээ байгуулах зөвшөөрөл олгохыг хүссэн хүсэлтийг Хороонд бичгээр ирүүлж, уг хүсэлтэд давхар даатгагчийн тухай мэдээлэл, давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай эвшөөрлийн гэрчилгээний хуулбар, гэрээнд оролцох хувь хэмжээ, тухайн давхар даатгагчийг сонгосон шалтгаан зэргийг дэлгэрэнгүй тусгана. Хороо хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор шийдвэрлэх бөгөөд хэрэв давхар даатгагчийг зөвшөөрөхгүй байх тохиолдолд энэ тухай үндэслэлийг даатгагчид албан бичгээр хүргүүлнэ.

4.4 Давхар даатгагч энэ журмын 2.6-д заасан шалгуурыг хангасан, эсхүл даатгалын нэг гэрээг хэд хэдэн давхар даатгагчид даатгуулах тохиолдолд давхар даатгалын гэрээнд оролцогч аль нэг компани эвшөөрөгдөх давхар даатгагчийн шалгуурыг хангасан байвал Хорооноос давхар даатгалын гэрээ байгуулах зөвшөөрлийг авах шаардлагагүй.

4.5 Хороо нь давхар даатгалын гэрээ байгуулах зөвшөөрөл олгохдоо дараах нөхцлүүдийг харгалзан үзнэ:

4.5.1 Давхар даатгагч нь энэхүү журмын 3.3, 3.4-т заасан давхар даатгалын төлөвлөгөөнд тусгагдсан эсэх, давхар даатгалын өлөвлөгөөнд заасан шалгуур үзүүлэлтүүдийг хангаж буй эсэх;

4.5.2 Давхар даатгагчийн санхүүгийн чадавхи;

4.5.3 Давхар даатгалын гэрээний дагуу даатгагчийнөөртөө үлдээх даатгалын эрсдэлийн хувь хэмжээ нь үндэслэлтэй эсэх;

4.5.4 Гадаад улсад давхар даатгалын үйл ажиллагаа явуулдаг давхар даатгагч бүс нутгийн давхар даатгалын хяналт зохицуулалтын байгууллагын хяналтад байгаа эсэх, тухайн орны давхар даатгагчид тавигдах шаардлагыг хангасан эсэх;

4.5.5 Давхар даатгалын гэрээ нь факультатив болон гэрээт давхар даатгалын гэрэээм эсэх;

4.5.6 Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл.

4.6 Даатгагч нь энэ журмын 2.5д заасан давхар даатгалын хамгаалалтыг давхар даатгалын гэрээ байгуулах үед даатгуулагчид санал болгох эрхтэй.

#### **Тав.Фронтингийн үйл ажиллагаа**

5.1 Даатгагч нь энэ журмын 5.2-т дурьдсанаас бусад тохиолдолд фронтингийнүйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

5.2 Шаардлагатай зарим тохиолдолд даатгагч болон даатгуулагчийгсэлтийг үндэслэн Хорооноос тухайн даатгагчид нэг жилийн хугацаанд фронтингийн ажиллагаа явуулах нэг удаагийнөвшөөрөл олгож болно. Энэ тохиолдолд даатгагч фронтингийн даатгал эрхлэх зайлгүй шаардлага, үндэслэл, давхар даатгагч, давхар даатгалын зуучлагчийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, даатгагчийн хувь оролцоог тусгасан баримт материал бүхий хүсэлтийг Хороонд бичгээр ирүүлнэ.

5.3 Хороо фронтингийнүйл ажиллагаа явуулах даатгагчийн хүсэлт, холбогдох материалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 15 хоногийн дотор хянаж, хариуг албан бичгээр өгнө.

5.4 Даатгагч нь Хороонооссэн зөвшөөрлийн хүрээнд фронтингийн үйл ажиллагаа явуулах бөгөөд зөвшөөрөлд тусгагдаагүй нөхцөлөөр даатгалын болон давхар даатгалын гэрээ байгуулахыг хориглоно.

**Зургаа. Давхар даатгалын гэрээ байгуулах үйл ажиллагаа, давхар даатгалын тайлан,**

**түүний биелэлтэд хяналт тавих**

6.1 Даатгагч нь давхар даатгалын гэрээ байгууллагчийг биелэлт, давхар даатгалын нэхэмжлэл, нөхөн төлбөр, эрсдэлийн байдалд хяналт тавих үүрэг бүхий дотоод хяналтын нэгжтэй байна.

6.2 Хороо нь даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөөний биелэлт буюу давхар даатгалын гэрээ байгуулах үйл ажиллагаанд тавих хяналт шалгалтыг Хорооноос баталсан холбогдох журмын дагуу хийж гүйцэтгэнэ.

6.3 Хороо нь давхар даатгалын үйл ажиллагаанд хяналт тавих асуудлаар гадаад улс орнуудын даатгалын хяналт, зохицуулалтын байгууллагатай хамтарч ажиллана.

6.4 Даатгагч нь Даатгалын тухай хуулийн 48 дугаард заасны дагуу давхар даатгалын төлөвлөгөөний нарийвчилсан тайланг гаргаж, жил бүрийн 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

6.5 Давхар даатгалын тайланд давхар даатгалын хамралт, эрсдэл, хураамж, өмнөх төлбөр, давхар даатгалын гэрээ хэлцэл, тэдгээрийн дугаар, давхар даатгагч болон давхар даатгалын зуучлагчийн нэрсийн жагсаалт, давхар даатгалын үйл ажиллагааны үр дүнг дэлгэрэнгүй харуулсан санхүүгийн тайлан зэргийг тодорхой тусгаж, компанийн давхар даатгалын үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналтын тайлан болон давхар даатгалын гэрээний хуулбарыг хавсаргасан байна.

6.6 Давхар даатгалын тайлангийн бодитой эсэхэд Хороо хяналт тавина. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Хороо дараах нэмэлт материалыг шаардаж болно.

6.6.1 Давхар даатгалын гэрээ хэлцлүүд, тэдгээрт оруулсан өөрчлөлтүүд;

6.6.2 Давхар даатгалын баталгаа (reinsurance slip) болон давхар даатгалын мэдэгдэл (cover note)-ийн хуулбар;

6.6.3 Давхар даатгалын хугацаат өлбөрийн баримтуудын хуулбар (төлбөрийн шилжүүлэг хийгдсэн тохиолдол бүрт);

6.6.4 Өмнөх хяналт шалгалтын тайлан, шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний талаарх танилцуулга, тодруулга;

6.6.5 Давхар даатгалын гэрээний үзүүлэлтүүдээр гаргасан нэгтгэл болон бусад материал.

6.7 Хороо даатгагчийн давхар даатгалын гэрээний нууцлалыг хадгалах, уг гэрээний талаарх мэдээллийг хуульд зааснаас бусад, эсхлү даатгагч өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд бусдад өгөхийг хориглоно.



6.8 Даатгагч нь компанийн засаглалын кодексийг хэрэгж үлэх хүрээнд давхар даатгалын үйл ажиллагааны тайланг компанийн ТУЗ, эсхүл түүнтэй адил эрх бүхий этгээдэд улирал бүрийн эхний 7 хоногт танилцуулна.

#### **Долоо.Бусад**

7.1 Хороо нь энэ журмын биелэлтэд хяналт тавих бөгөөд журмыг зөрчсөн этгээдэд Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--ooOo--